


ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА-2



УЛААНБААТАР ХОТ
2018 ОН

ӨМНӨХ ҮГ

Энэхүү гарын авлагад хүүхдийн нас сэтгэхүйн онцлог, хүүхдийн хүмүүжлийн талаар тусгасан бөгөөд хүүхдийн хүсэл сонирхлыг мэдэрч, зөв удирдан залж, асуудлыг эерэг аргаар шийдвэрлэж сурахад хүүхдэд тусалж дэмжих, хүүхэд хамгааллын ээлтэй орчин бүрдүүлэх мэдлэг, чадвартай эцэг эхчүүдийг бэлтгэхэд энэхүү ном та бүхэнд туслах болно.

Хүүхэд Өсвөр Үеийг Ивээх Төвийн хамт олноос

ХҮҮХДИЙН НАС СЭТГЭХҮЙН ОНЦЛОГ


НЯРАЙН ҮЕ

Энэ үед хүрээлэн буй орчинд итгэх суурь итгэл бүрэлдэнэ. Иймд хүүхдийг тэвэрч, түүн рүү инээж, бүүвэйлж, ярилцана. Хүн амьдралынхаа эхний долоо хоногуудад бие болоод сэтгэлзүйн хувьд эрүүл хүн болох анхны суурь тавигддаг. Өөрөөр хэлбэл, нялхас эрүүл өсөж бойжихоос гадна сэтгэлзүйн төлөвшилт нь бие даасан, өөртөө итгэлтэй болоход эхний долоо хоногт түүнийг хүлээн авсан ертөнц, асран халамжлах хүний харилцаа шийдвэрлэх үүрэгтэйг судлаачид тогтоожээ. Хэрэв найдвартай, халамжтай хүмүүсээр хүрээлэгдсэн бол уг орчноос суралцаж, итгэл хэмээх суурь мэдрэмж нь төлөвшин хөгждөг аж.



БАГА НАС

Энэ үед хүүхэд өөрийгөө бие даасан, чөлөөтэй гэдгийг ойлгон, түүнээ хамгаалж, бусдаас хамааралгүй шинэ “Би”-тэй болсноо нотлохыг хичээнэ. Энэ бүхэн хүүхдийг хөлд орсон цагаас эхэлнэ. Ичих, эргэлзэх мэдрэмжтэй болно. Ийм нөхцөлд хүүхдийн бие даах эрмэлзлийг хэт цээрлэж, хорих нь цаашид үргэлж эргэлзэх, ичих хандлагатай болгох аюултай. Тэд сэтгэлийн хөдөлгөөндөө удирдуулдаг болохоор түүнийгээ барьж чаддаггүй. Магтаалын үг дуулахын тулд бүхнийг хийнэ. Хэл ярианы хөгжилтэй холбоотойгоор түүний дүрслэн бодох, сэтгэхүйн ажиллагаа хөгжинө. Тоглоомоос сэтгэлийн асар их баяр баясгалан олж авна. Эцэг, эхдээ хязгааргүй хайртай, өөртөө ч сэтгэл хангалуун байна.



ТОГЛОЖ НААДАХ НАС

Энэ шатанд идэвхтэй эрэлхийлэн хэрэгжүүлэх, санаачилга гаргах чадвар бүрэлдэн тогтдог. Харилцааны нэг гол хэлбэр бол өөрийгөө магтах, бие биедээ гайхуулах зан. Шулуун шударга, эрс хурц зантай байдаг тул багагүй бүдүүлэг харилцаатай, бусад хүний санаа бодол, хүсэл сонирхол түүнд хамаагүй мэт авирлана. Маргахдаа амархан, сэтгэлийн гүн хөдөлгөөнтэй, эсвэл ичимхий, үг дуугүй байдал гаргана.



СУРГУУЛИЙН НАС

Энэ насанд өөрийгөө бусадтай адилгүй зан чанартай, мөн бусдаас сул дорой гэсэн мэдрэмж хэт давамгайлах нь бий. Сургуулийн зүгээс тавьж байгаа шаардлагад нийцэхгүй бол сургууль хүүхдийн хувьд ач холбогдлоо алдаж, гэр бүл нь хамгийн таатай, дотно газар нь болж хувирдаг. Өөрсдөдөө анхаарал тавихыг гол болгоно. Тойрон буй хүмүүсийн анхаарлыг өөртөө татахын тулд янз бүрээр оролддог. Биеэ магтах дуртай болно. Түм буман удаа “Яагаад” гэж асууна.




ХЯМРАЛЫН ҮЕ БУЮУ ӨСВӨР НАС

Энэ бол хүүхдийн сэтгэл зүй ихээхэн өөрчлөгддөг эгзэгтэй бас эрсдэлтэй, мөн хамгийн чухал нас. Энэ шатанд хүүхэд нас дуусч, бие даасан том хүний амьдралд хөл тавихтай холбоотойгоор гүнзгий хямрана. Энэ насанд хүүхдийн бэлгийн бойжилт гүйцэхээс гадна сэтгэл зүйн хувьд насанд хүрдэг. Улмаар энэ насны хүүхэд сэтгэл санаа болон биеийн хувьд өөрийгөө эцэг, эхээсээ тусгаарлаж өөрийн гэсэн үнэт зүйл, үзэл бодол, танилын хүрээтэй болохыг эрмэлзэж эхэлнэ. Тун саяхныг хүртэл шимтэн сонсдог байсан эцэг, эхийнх нь үг, бодол үнэ цэнээ алдаж, үе тэнгийнхний нь бодол санаа илүү ач холбогдолтой болж ирнэ.

Насанд хүрч бие даах үйл явц хүүхэд болгонд адилгүй. Зарим хүүхэд сэтгэл санааны дотно байдлаа огцом тасалж, хэт түрэмгий, бодит шалтгаангүй үгүйсгэсэн харьцаатай болж, юм болгон дээр өөрийн бие даасан, тусгаар байдалтай харуулах гэнэ. Тийм ч болохоор гэр бүлийнхээ уламжлал, дэг жаягийг ямагт эсэргүүцдэг. Эцэг, эхчүүдийн харьцаанд хямрал үүсдэг. Үүний эцэг эхчүүд бэлтгэлтэй байж, заримдаа наанаа элдэв сөрөг үзэгдэл илэрдэг ч дотроо хүүхдийнх нь ирээдүйд чухал үүрэг гүйцэтгэх эерэг өөрчлөлтүүд гарч байдаг гэдгийг ойлгодог байх ёстой.

Үүнээс гадна дан ганц эцэг, эхчүүдэд төдийгүй хүүхдүүдэд ч хэцүү байдаг гэдгийг мартаж болохгүй. Хүүхэд ба эцэг, эхчүүд хоорондын харьцаа нь ойлголт, ухаалаг хяналт, халамж дээр тогтож байх ёстой. Иймд хүүхдээ тоохоо болих, эсвэл хэт хатуу хяналтад байлгах нь буруу юм. Хамгийн байж боломгүй зүйл нь сэтгэлийн хэлхээс тасарч, хүүхдийг зөнд нь орхих юм.




Хүүхдийн физиологийн хөгжил, бэлгийн бойжилт эрчимтэй явагдаж бэлгийн хоёрдогч шинж тэмдгүүд илрэн охид эмэгтэй хүний, хөвгүүд эр хүний намба төрхтэй болдог учраас шилжилтийн нас гэж нэрлэдэг.

Энэ насны хүүхдийн гадаад ертөнц рүү хандсан сонирхол, хэрэгцээ нь дотоод ертөнц рүү чиглэж эхэлдэг. Өөрөөр хэлбэл тэд өөрийн зан чанар, намба, төрхөө бусадтай харьцуулан дүгнэж эхэлдэг. Өсвөр насны хүүхдийн сэтгэл санааны байдал огцом өөрчлөгдөж тайван хүүхэд цочмог болж, идэвх нь буурах, нийтэч байсан хүүхэд зожигрох, уур бухимдлаа гадагшлуулахдаа түрэмгий авирлах, томчуудыг эсэргүүцэх, сөргөлдөх, нийгмийн хэв журам зөрчих зэргээр илрэх магадлал өсдөг.

Энэ нь өсвөр насны хүүхдийн дотоод шүүрлийн булчирхай идэвхтэй ажиллаж тэр нь мэдрэлийн тогтолцооны үйл ажиллагаанд нөлөөлдөгтэй холбоотой юм. Тэгэхлээр энэ насанд эцэг эхчүүд энэ онцлогийг нь харгалзаж, тэднийг аливаа нөхцөлд тайван тогтуун байлгаж, сайн талд нь түшиглэж ажиллах хэрэгтэй. Энэ насанд танин мэдэх сонирхол, эрчимтэй хөгжиж шинжлэх ухаан, техник, утга уран зохиол унших, секц дугуйланд суралцах идэвхтэй байдаг.

Өсвөр насны үед найз нөхөдтэйгөө харьцах харилцаа нэн чухал үүрэг гүйцэтгэдэг. Найз нөхдийн харилцах харилцааны хүрээлэл эрс өөрчлөгдөж, үзэл бодол нийлдэггүй байсан хүүхэдтэйгээ нэгдэж эсвэл зожигрч, ганцаардах, өөрийгөө бусдын дунд зохистой байр суурь эзлэх чадваргүй гэж чамлах, төрөл бүрийн нэр хочноос айх зэрэг шинж байдал ажиглагддаг.



ХҮҮХЭДТЭЙГЭЭ ХЭРХЭН ЯРИЛЦАХ ВЭ?


Өсвөр үеийнхний дунд хийсэн судалгаанаас:

Ямар нэгэн асуудал тохиолдоход хамгийн түрүүнд хэнд хэлэх вэ гэсэн асуултанд 90% нь найздаа гэж хариулсан бөгөөд 7% нь эцэг эхдээ, 3% нь хүнд хэлэхгүй гэж хариулсан байна.

Найзтайгаа хамтран асуудлыг шийдвэрлэхдээ асуудлыг улам хүндрүүлдэг бөгөөд тухайн асуудлыг шийдвэрлэхэд нилээд хүндэрсэн хойно эцэг эхчүүд мэддэг байна.

Тиймээс хүүхдийнхээ асуудлыг хамгийн түрүүнд сонсдог, хүүхэдтэйгээ ярилцдаг байх нь хүүхдээ аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх хамгийн чухал зүйл юм.

Хүний амьдралын нэг мөчлөг өсвөр нас байдаг. Энэ үеийг хэн ч тойрч гарахгүй туулаад гардаг нь жам. Энэхүү үеийг эмзэг, мэдрэмтгий нас гэж тодорхойлох нь бий. Тиймээс тэдэнтэй хэрхэн харилцвал илүү үр дүнтэй байдаг талаар бяцхан зөвлөгөөг хүргэж байна.



ГЭР БҮЛДЭЭ

ХАЛУУН ДУЛААН УУР АМЬСГАЛЫГ БИЙ БОЛГО

Хүүхэд тань аз жаргалтай, өөрийнхөөрөө байх орчин бол яах аргагүй гэр бүл билээ. Тиймээс тэдэнд сэтгэл санаа нь тайван, аз жаргалтай байх боломжийг олгож гэр бүлийн уур амьсгалаа халуун дулаан болгоорой. Амралтын өдрийг хамт өнгөрөөж, тэдэндээ цаг гаргаж байгаарай. Гэр бүлийн байнгын хэрүүл шуугианаас хүүхэд маш их залхаж, сэтгэлийн дарамтанд ордог. Тиймээс үл ойлголцол гарвал хүүхдийнхээ дэргэд хэрэлдэлгүй, тайвнаар ярилцах (эсвэл байхгүй байхад нь ярилцах) хэрэгтэй.

ХҮҮХДИЙНХЭЭ ДАВУУ САЙН ТАЛЫГ МЭДЭРЧ, ДЭМЖИН МАГТАЖ БАЙ

Өсвөр насны гэлтгүй бүхий л насны хүүхдүүд магтаал урамшуулалд дуртай байдаг. Нэг үгээр тэд магтаал, урмын үгсээс эрч хүч авч урагшилж байдаг бяцхан хүмүүс юм. Заавал онц сурах албагүй ч ямар нэгэн зүйлдээ сайн, бүр маш жаахан ахиц амжилт гаргасан ч хүүгээ, охиноо магтаж бай, амжилтаа дахиад ахиулахыг хичээгээрэй гээд үнсээрэй. Тэд урмын дулаан үгээр дутаж явдаг юм шүү.

Тэднийг өдрөөс өдөрт бие дааж байгааг нь хүлээн зөвшөөрч бие даах боломжийг нь олгож байх

“Чи хүүхэд.., чи жаахан.., чи том хүн биш...” гэсэн тодорхойлолтод тэд тийм ч дуртай биш. Хүн ер нь хүүхэд байж байгаад нэг л өдөр гэнэт том хүн болчихгүй шүү дээ. Тэд энэ хоёр зүйлийн дунд байгаа нэгэн юм. Тиймээс түүнд бие даах, өөрийнхөө үзэл бодлыг илэрхийлэх боломжийг нь олгож бай. Аливаа чухал шийдвэрт саналыг нь асууж бай, ямар нэгэн санал гаргахад дэмжин ярилцаж боломжтой бол асуудалдаа тусгаж бай, тэдэнд бие даах боломжийг нь олгож эхэл. Эс тэгвээс том болсон ч бие даах чадваргүй, юм болгоныг эцэг эхээрээ хийлгэх гэдэг нэгэн болчихож мэднэ.



Та хүүхдийнхээ маш сайн сонсогч, ярилцагч нь байх хэрэгтэй

Хичээлээсээ ирээд тухайн өдөрт болсон зүйлээ, сонин хачин мэдээллээ тэр танд байнга хуваалцдаг бол та маш сайн сонсогч. Тэдний хамгийн сайн найз, сонсогч нь эцэг эх нь байх ёстой. Хэрэв тийм ч нээлттэй биш байдаг бол та одооноос өөрөө эхний алхмаа хийгээд үзээрэй. “Өнөөдөр юу хийв дээ, миний хүү?” гээд яриагаа эхэлсэн ч болно. Тэр хэд хоногийн дараагаас танд нууцаа ярьж зөвлөгөө авахыг хүсэх вий. Амьдралынх нь эхлэл хэсгийн замд буруу зөвийг нь зааж өгөх залуурч нь эцэг эх нь учраас сайн сонсогч, сайн ярилцагч, зөвлөгч нь байхыг хичээ.

Тэдний итгэлтэй дотны найз байдлаар харилцаж байхыг эрмэлз

Танд хэлдэггүй байж болох ч заримдаа тэд ганцаарддаг. Найзгүй гэдгээ эсвэл найзтайгаа үл ойлголцоод харьцахгүй байгаагаа танд хэлдэггүй байж болно. Харин та хэзээд түүний дэргэд байх сайн найз нь болохыг хичээгээрэй. Охинтойгоо хамт дэлгүүр хэс, үзмээр байгаа киног нь хүүтэйгээ цугтаа үз. Яг л найзууд шиг цагийг хамтдаа өнгөрүүл. Мөн дүүд нь анхаарал тавьдаг шигээ түүнд ч мөн анхаарал хандуулж, ярилцаж цаг зориулж байгаарай.

Тэднийг загнахаас илүүтэй учирлаж хэл

Хэдий уур чинь хүрсэн ч загнахаа бүү урьтал болгоорой. Тэд аливаа зүйлийг сайн ойлгохтойгоо болсон учир алдаа гаргасан тохиолдолд учирлаж хэлж тайлбарла. Амьдралд юу нь буруу, юу нь зөв гэдгийг тэд хараахан мэдэж амжаагүй учир сониуч зандаа хөтлөгдөн алдаа гаргаж л таараа. Харин тухайн зүйлийн учир шалтгааныг өөрөөр нь тайлбарлуулах боломжийг олгох хэрэгтэй. Алдаа бүр дээр нь толгой түрүүгүй загнаж, гар хүрэлгүй харин ч эвээр ярилцан асуудлын голыг тайлбарлаж, бүр өөрийн жишээг иш татаж өсвөр насны амьдралын дурсамжаа ярьсан ч болно.

Итгэж ярьсан нууц болох “нууц”-ыг нь чанд хадгал

“Аавд битгий хэлээрэй” гээд танд нэг зүйлийг итгээд хэлсэн ч та аавд нь (нөхөртөө) хэлж болохгүй. Энгийн жижиг гэлтгүй түүний нууцыг хэнд ч битгий хэл, учир нь тэр нууц түүний хувьд үнэ цэнтэй зүйл юм шүү дээ. Хэрэв түүний нууцыг хэн нэгэнд сонин хачин болгож хэлээд, түүнийг нь хүүхэд тань мэдчихвэл тэр танд дахиж нууцаа хэлэхгүй.

Хүүхдийнхээ сэтгэлзүйг мэдрэхийг хичээгээрэй

Охин, хүү тань дуугаа хураагаад нэг л өөр байгаад байна уу. Тэр магадгүй дурласан, найддаа гомдсон, эсвэл шалгалтандаа хангалтгүй авсан ч байж болно. Хайртай хүү, охиноо ажиглаж бай. Гаргаж байгаа зан ааш, сэтгэлийн хөдлөл, үйлдэл бүр нь ямар нэгэн зүйлийг илэрхийлж байдаг. Тиймээс тэдний хэрэгцээг мэдэрч дотоод сэтгэл рүү нь харж байхыг эрмэлз. Тиймээс ярилцаж, ойр дотно бай.



Өөрийнхөө хувийн бодлыг хэзээ ч бүү тулга

“Би бол чиний ээж (аав) учир миний үгээр бай” гэх хандлагатай эцэг эхчүүд цөөнгүй байдаг. Гэхдээ заримдаа энэ хандлагыг хязгаарлах хэрэгтэй. Түүний үзэл бодол, саналыг сонсож асуудлыг хэрхэн шийдвэрлэж болох арга замыг хай. Дээр дурдсанчлан бие даах боломжийг нь олгож өөрөө шийдвэр гаргахад нь тусал. Амьдралд алдаж байж ухаардаг хойно, тэр гаргасан алдааныхаа дараа таны үгийг үнэ цэнтэй байж гэдгийг мэдэрсэн ч болно. Мөн түүний огтоос хүсэхгүй байгаа мэргэжлээр хүчлэн суралцуулах гэж байгаа бол энэ талаар түүнтэй дахин ярилцаж асуудлыг шийдвэрлэх арга замыг хайгаарай.

Эрүүл зан үйлийг төлөвшүүлэн дэмжиж бай

Та хүүхдээ ямар дадалтай болгомоор байна. Спортоор хичээллэдэг, түргэн хоол коланаас илүүтэй эрүүл хоол иддэг, ном уншдаг, гоё хоббитой хүсэл тэмүүлэлтэй нэгэн байгаасай гэж хүсэж байна уу. Тэгвэл өөрөөсөө эхлээрэй. “Цэцэрлэгт хүрээлэн орж дугуй уная” гэсэн хүүгийнхээ саналыг баярлан дэмжиж бай. “Гоё хоол хийх арга заагаад өг эсвэл хамт бялуу хийе” гэсэн охиныхоо саналыг дуртайяа хүлээж ав. Тэд бидний толь юм шүү, хайртай хүүгээ охиноо ямар хүн болоосой гэж хүсэж байна өөрөө үлгэр жишээ байхыг хичээгээрэй.



ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЭЛ

**БИЕ МАХБОДЫН ХҮЧИРХИЙЛЭЛ
БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ
СЭТГЭЛ САНААНЫ ДАРАМТ
ҮЛ ХАЙХРАХ ЯВДАЛ**

Хүүхдийн бие махбодид шууд халдах хүчирхийллийн явцуу хэлбэрээс гадна хүүхдийн хэвийн хөгжилд

саад болох олон талт нөлөөг тооцон өргөн хүрээнд тодорхойлно.

БИЕ МАХБОДЫН ХҮЧИРХИЙЛЭЛ


Илрэх шинжүүд: Хүүхдийн бие дээр ил харагдах бэртэл, гэмтэл; нэг бус удаа ижил төрлийн гэмтэлд өртсөн байдал; удаан хугацааны туршид байнга давтагдах байдлаар илрэх гэмтэл; ямар нэг эд зүйлс, хурууны хэлбэртэй улайлт, хөхрөлт; бага насны хүүхдийн нүүрэнд дээр зүсэгдсэн, хөхөрсөн ба няцарсан эдийн гэмтэл, сорви гэх мэт



БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл гэдэг нь хэн нэгэн насанд хүрсэн хүн эсвэл насаар ах эсвэл хүч чадал илүү хүүхэд нөгөө хүүхдээ бэлгийн аливаа үйлдэлд ашиглахыг хэлнэ.

Илрэх шинжүүд: Хүүхдийн бие, бэлэг эрхтний эд эрхтэнд илрэх гэмтэл, өөрчлөлтийн шинжүүд, мөн хүүхдийн сэтгэл санаа, зан үйлд гарсан өөрчлөлтүүд тухайлбал тайван бус болох, өөрийгөө зүсэх ба хөхрүүлэх, хүүхэд хэвийн явж сууж чадахгүй болох, дотуур хувцас нь толбо болох, жирэмслэх, бэлгийн замын халдварт өвчих тусах



СЭТГЭЛ САНААНЫ ДАРАМТ

Хүүхдийг үл хайхрах хандлагаас эхлээд хүүхдийн өсөлт хөгжлийн хэвийн байдлыг хангах үүргээсээ татгалзах хүртэл хүүхдийн сэтгэл санаанд дарамт үзүүлэх бүхий л хандлага, зан үйл бүгд сэтгэл санааны дарамтанд хамаарна.

Сэтгэл санааны дарамтын үед илрэх шинжүүд: санаа зовох, дуугаа хураах, өөрийгөө хохироох үйлдэл хийх, эсвэл бусдад хэрцгийгээр хандах

Хүүхдийн бие махбод болон зан үйлд мөн өөрчлөлт илэрнэ. Үүнд: шээсээ барьж чадахгүй болох, гүйлгэх, сэтгэл санааны дарамтаасаа болж өвчин зовиуртай болох, толгох өвдөх гэх мэт бүтэлгүйтэхээс айх, өөртөө өндөр

шаардлага тавих, худлаа ярих, дотогшоогоо чиглэлтэй болох



Хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийг үл тоон, анхаарал халамж хангалтгүй үзүүлсний улмаас хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, эрүүл мэндэд нь хохирол учруулахыг хүүхдийг үл хайхрах явдал гэнэ.

ҮЛ ХАЙХРАХ ЯВДАЛ

Илрэх шинжүүд: хүүхэд анхаарал халамжинд байхгүй шинжүүд тухайлбал хиртэй, томдсон эсвэл багадсан насанд тохироогүй хувцаслах, хувийн ариун цэвэр муу байх, хараа хяналтгүй болох, арьс болон бусад өвчтэй удаан явах, гэх мэт

Зан авирт илрэх шинжүүд: Сэтгэл санаагаар унах, сэтгэл хөдлөлөө барьж хянаж чадахгүй байх, анхаарал халамж бусдаас байнга хүсэх, шаардах, элдэв хэрэг зөрчилд холбогдох, хичээл дээрээ унтах гэх мэт



ГЭР БҮЛИЙН ОРЧИНД ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН ХАРИЛЦАА



Бага насны хүүхдийн хөгжил нь тэдний эрүүл, эсэн мэнд төрж, бойжих, шаардлагатай хоол тэжээлээр хангагдах, эцэг эх, ойр дотны хүмүүсийн хайр халамж, хамгаалалд өсч хөгжих, сурч боловсрох зэргийг хамарсан өргөн хүрээтэй асуудал тул орчин үед бага насны хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, асаргаа, халамж, хамгаалал, боловсролын үйлчилгээг цогц авч үзэж, харилцан уялдаа холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэх болж байна. Хүүхэд хүртэх эрхтэй хайр халамж, хамгаалал, хоол тэжээл, эрүүл мэндийн асаргаа, сурч боловсрох боломжийг нэн тэргүүнд бүрдүүлэх хамгийн анхдагч орчин нь гэр бүл гарцаагүй мөн. Гэр бүлийн гишүүд бол хүүхдийн анхны багш. Хүүхэд цэцэрлэгт орохоосоо өмнө гэр бүлдээ аяга барих, уух, бөмбөг шидэхээс эхлээд үлгэр баясан сонсох хүртэл олон зүйлийг сурсан байдаг. Эцэг эхчүүд хүүхдээ энгийн чадваруудад сургахын зэрэгцээ хил хязгаарын ойлголт, бусдын мэдрэмжийг хуваалцах зэрэг олон үйл ажиллагаанд сургадаг. Харамсалтай нь хүүхдээ цэцэрлэгт орсны дараа хүүхдээ сургах, үлгэрлэх үйл ажиллагаа нь “зогсонги” байдалд орж эхэлдэг. Иймээс цэцэрлэгийн багшийн зааж сургаж буй бүхий л үйл ажиллагаануудад гэр бүлийн гишүүд оролцож, хамтран ажилласнаар хүүхдийн хөгжлийг бүрэн дэмжих боломж бүрдэнэ. Бага насны хүүхдийн бойжилт хөгжилтөд гэр бүлийн үүрэг их юм. Хүүхэд гэр орондоо хүмүүждэг. Гэр орондоо болж байгаа зүйлийн нөлөөнд хүүхэд төлөвшиж, хүмүүжиж байдаг. Гэр бүлийн гишүүд хүүхдийнхээ амьдралд үргэлж асрагч, багш нь болдог. Тиймээс бага насны хүүхдийн эцэг эх хүүхдийнхээ анхдагч эерэг чанарыг таних, зоригжуулах, бэхжүүлэх шаардлагатай. Хүүхдийн хөгжилд эцэг эхийн оролцоо хэдий чинээ их байх тусам тэдний бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийн үзүүлэлт нь төдийчинээ сайн байдаг байна.


ЭЦЭГ ЭХЧҮҮД ХҮҮХЭДТЭЙГЭЭ

ХЭРХЭН АЖИЛЛАХ ВЭ?



Хүүхэд бүр төрсөн цагаасаа л эхлэн өөр өөрийнхөө орчин ахуйтайгаа харилцан, өөр өөрийнхөөрөө сурч хүмүүншиж хүн болдог. Хүүхэд өөрийн төрөн өсч буй эрүүл хийгээд аюулгүй орчин ахуйгаасаа сурч хүмүүншихүйн үр дүнд бие хүн болон төлөвшдөг. Энэ орчин ахуйн бага насны хүүхдэд хамгийн ойр, анхдагч хэсэг нь гэр бүл нь юм. Хүний амьдралын эхний 5 жилд олж эзэмшсэн мэдлэг, чадвар, төлөвшил нь тухайн хүнийг хэн болохыг бүрэн тодорхойлдоггүй ч цаг хугацаа урсан өнгөрөх тусам өөрчлөх боломжгүй чиг баримжааг олгож цаашдын хөгжлийг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүүхдийн оюун ухаан, бие бялдар, нийгэмшихүйн хөгжлийн ялгаа бага насанд нь л илэрч эхэлдэг бөгөөд сургуульд элсэн орох үед улам гүнзгийрдэг бөгөөд хүүхдийн хөгжлийн энэхүү ялгаатай байдал нь нийгэм-ахуйн орчин нөхцлөөс ихээхэн шалтгаалдаг. Бага насны хүүхдийн хөгжилд өрхийн орлогын хүрэлцээ, орон сууцны нөхцөл, эцэг эх, асран хамгаалагчдын боловсролын түвшнээс илүүтэй гэр бүл, эцэг эхийн зүгээс хүүхдэд тавьж буй анхаарал халамж, хүүхдийн хөгжлийн талаарх ойлголт, мэдлэг, туршлага нэн чухал. Хүүхдийн хөгжилд нөлөөлдөг чухал хүчин зүйлүүдийн нэг нь эцэг эх, асран хамгаалагч болон хүүхдийн хоорондын ээнэгшин дасах холбоо билээ. Хүүхэд ямар хүн болж төлөвших нь гэр бүлд шийдэгддэг тул эцэг, эхчүүд хүүхэдтэйгээ багаас нь яаж харилцаж, ажиллах, хүүхдээ юунд сургах, ямар чадвар дадал эзэмшүүлэхийг сайн мэддэг байх ёстой.

Хүүхдийн хүсэл сонирхлыг мэдэрч, зөв удирдан залж, амьдрах чадвартай, асуудлыг шийдэх, нийгэм, хамт олны идэвхтэй гишүүн, “зөв хүн” болоход нь тусалж дэмжих нь эцэг эхчүүдийн үүрэг юм. Түүнчлэн хүүхдийн өсөлт хөгжилд гэр бүлийн гишүүдийн тэгш оролцоо чухал үүрэгтэй.



ХҮҮХДИЙНХЭЭ ХЭЛ ЯРИАГ ХӨГЖҮҮЛЭХ. Бага насны хүүхэд өөртэйгөө хамт байгаа, өөрийнхөө хажууд байгаа орчин ахуйгаасаа сурч хүмүүнших аргад, өөрөө боловсрох үйлд сурдаг, бас хөгждөг, сургуульд ч бэлтгэгддэг. Харин энэ үед нь эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ хэлж ярьж байгаа зүйл, тоглож байгаа тоглоом, асууж байгаа асуултыг анхааралтай сонсож, хүүхдийнхээ хөгжилд гарч буй ахиц амжилтыг нь сайшаан дэмжиж, буруу гажуу зүйлсийг нь засч залруулж өгч байх нь чухал.

0-2 насандаа хүүхэд бусадтай харьцах зайлшгүй шаардлага үүсэж, хэл яриа хөгжиж ирдэг. Энэ үед уураг тархины хэлэхүйн төвийн хөгжил маш эрчимтэй явагддаг ба энэ насанд үүссэн бүх л тааламжгүй нөлөө хүүхдийн хэл ярианы хөгжлийг саатуулж болох юм. Харин 2-5 насандаа хүүхдийн хэл яриа эрчимтэй хөгжиж холбоо үг, өгүүлбэрээр ярьдаг болно. Энэ үед хүүхдийн хэл яриа эмзэг байдаг учир элдэв буруу нөлөөнөөс хамгаалбал зохино. Мөн ээрүү үүсэж болзошгүй учир анхааралтай байх хэрэгтэй¹. Хүүхдийнхээ хэл яриаг хөгжүүлэх талаар эцэг эхчүүд юуг анхаарч, яаж ажиллах талаар доорх зүйлүүдийг анхаарч, хэрэгжүүлэх хэрэгтэй. Үүнд:

- ▲ Хүүхдийн нас биений онцлогийг харгалзан хүүхдийнхээ хэл яриаг зөв хөгжүүлэх
- ▲ Хүүхэдтэйгээ ярилцахдаа заавал эргэж хариултыг нь авдаг байх.
- ▲ Хүүхдэд тань хэл ярианы гэм согог илэрвэл хүүхэдтэйгээ хэрхэвч дохио зангаагаар ярьж болохгүй. Үүнээс аль болох татгалзан эмч, мэргэжлийн хүнээс зөвлөгөө авах хэрэгтэй.
- ▲ Нялх хүүхэдтэйгээ хүртэл чин сэтгэлээсээ харьцахад хариуд нь хүүхэд сэргэж, хөдөлгөөн нь идэвхжин авиа гарган инээж баясна.
- ▲ Хүүхэдтэйгээ хэт өндөр биш, хэт нам биш дуугаар, дунд зэргийн хурдтай яриагаар ярилцаж байх хэрэгтэй. Хүүхэд орчны хүмүүсийн хэл яриа, хөдөлгөөнийг дуурайж хэлж ярьдаг тул хүүхдээ энхрийлэн эрхлүүлэхдээ хэлээ хазаж ярьж болохгүй. Хэрвээ ингэж ярьвал хүүхэд тань таныг дуурайж хэлээ хазаж яриад сурчихна.

ХҮҮХДЭЭ СОНСОХ. Хүүхэдтэйгээ харилцан ойлголцохын тулд тэднийг сонсох хүсэл тэмүүлэлтэй, тэдэнд цаг зав гаргадаг байх хэрэгтэй. Үүний тулд дууны өнгө, биеийн хөдөлгөөнөөр эрүүл, тааламжтай харилцаж ойлголцох таатай орчин нөхцлийг бий болгодог байх шаардлагатай. Ярьж ойлголцоно гэдэг нь харилцан яриа болохоос бус ганц хүний яриа биш юм. Тиймээс эцэг эхчүүд зөвхөн ярих биш харин хүүхдээ сонсоход суралцах хэрэгтэй. Хэрвээ бид зогсолтгүйгээр ярьж хүүхдэдээ ярих боломж олгохгүй бол түүнээс юу ч сонсохгүй, түүний тухай юу ч мэдэж авч чадахгүй. Хүүхэдтэй ярилцах үедээ нүд рүү нь харж, тогтуун тайван бай. Хэлж байгаа зүйлд нь юу гэж хариулахаа бодох биш, харин түүний хэлж байгаа зүйл дээр нь анхаарлаа хандуулж

¹ Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх арга зүйн гарын авлага., (2011), Улаанбаатар

сур. Өөр тийш харах, өөр зүйлийг хийхээр яарах, сонирхолгүй байгаа мэт харагдах, яаруу зандарсан байдлаар юм хэлэх, асуулт асуух гэж яарах, засаж залруулах юмуу зааж, залруулах гэх мэт байдлаас маань болоод хүүхэд томчуудтай ярихаа больчихдог талтай. Эцэг эх, хүүхдийн хоорондын харилцаанд сонсох нь маш чухал үүрэгтэй ба үүнд дараах зүйлс багтана.

- ▲ Хүүхдээсээ болзол шаардлагагүйгээр буюу нөхцөл байдлаас шалтгаалж бус харин ямарч нөхцөлд хайрладаг гэдгээ бид харуулах ёстой. Зарим тохиолдолд бид тэдний гаргаж буй зан байдал, үйлдлийг зөвтгөхгүй байж болно. Хүүхдэдээ хайрлаж байгаа гэдгийг ойлгуулж, үйл хөдлөлөөрөө харуулснаар хүүхдийн өөрийгөө үнэлэх үнэлэмжийг нэмэгдүүлдэг.
- ▲ Хүүхдийнхээ хийх дуртай зарим зүйлийг хамтран хийх. Жишээ нь, хамт зураг зурах, баримлын шавраар бүтээл хийж хамтдаа цаг хугацааг өнгөрүүлэх нь хүүхэдтэйгээ илүү сайн ойлголцохын зэрэгцээ, хүүхдийнхээ хувийн онцлог чанарыг илүү гүн гүнзгий ойлгоход тусалдаг.
- ▲ Бид дийлэнхдээ жаргалтай, баяртай, урам өгөх мэдээг хүүхдэдээ хэлж хуваалцдаг. Энэ нь эрүүл харилцааг бий болгоход тустай ч, заримдаа бэрхшээл, асуудлын талаар ч бас хуваалцах хэрэгтэй. Энэ нь хүүхдэд дарамт авчрах юмуу эсвэл бидний өмнөөс асуудлыг шийд гэж шаардаж байгаа явдал биш юм. Харин амьдралд тохиолддог бодит асуудал, сорилго бэрхшээлийн талаар ойлгож мэдэхэд нь тусална. Тухайн нөхцөл байдлуудыг яаж давж туулж, шийдэн зохицуулж байгаагаа хуваалцсанаар амьдралын зарчим, үнэт зүйлсийг үр хүүхдэдээ зааж сургана. Жишээ нь хүүхдийнхээ авах хүсэлтэй байгаа үнэтэй тогломыг авч өгөх санхүүгийн боломж гэр бүлд нь байхгүй байгаа тухай ярилцаж болно.
- ▲ Эрүүл бат бэх харилцааг бий болгохын тулд хүүхдэдээ чанартай цаг гаргах нь чухал юм. Хүүхдээ сонсоход тодорхой цаг хугацаа шаардагдана гэдгийг мэдэх хэрэгтэй.
- ▲ Эцэг эх болсноор амсдаг хамгийн сайхан мэдрэмжийн нэг нь хүүхэдтэйгээ хамт шинэ санаа, үйл явдал, газар орныг нээж илрүүлэх явдал байдаг. Энгийн зүйлстэй холбоотойгоор үүнийг хийж болно. Тухайлбал, унадаг дугуй яаж өнхөрч явдгийг, төрсөн өдрөө тэмдэглэх нь ямар учир шалтгаантайг, яагаад давс хоолонд амт оруулдаг тухай? олж мэдэх гэх мэт. Шинэ зүйл мэдэж авах иймэрхүү эрэл хайгуул нь санаа бодлоо солилцож, ярилцах өргөн боломж нээдэг.
- ▲ Хүүхдийг хайр халамжтай, аюулгүй орчинд сургаж, хүмүүжүүлэх хэрэгтэй. Тэднийг хайрлаж халамжилна гэдэг нь тэдний өмнөөс бүхнийг хийж өгнө гэсэн үг биш, харин хувийн үүрэг хариуцлагуудыг нь даалгах явдал үүнд багтдаг. Хүүхдийн нас биенд тохирсон ажил хийх боломжийг нь өгч, түлхэж дэмжих хэрэгтэй. Энэ бол үүрэг хариуцлагаа ухамсарладаг бие хүн болох эхлэл нь болно. Ингэхдээ багаас нь хайр халамж бүхий аюулгүй орчинд эдгээрийг хийлгэж эхлүүлэх хэрэгтэй. Хүүхэд гэмтэл бэртэл авч болзошгүй зүйлүүдийг урьдчилан шийдвэрлэсэн байх шаардлагатай. Тухайлбал халуун сав, халуун тогоо, цахилгааны утас, зэргийг хүүхдийн гар хүрэх газраас аль болох хол байлгах нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд онцгой нөлөөтэй гэдгийг анхаарах хэрэгтэй.

ХИЛ ХЯЗГААР ТОГТООХ, ЭНЭ ТАЛААР ХҮҮХДЭД ХЭРХЭН ОЙЛГУУЛАХ ВЭ?

Хүүхдүүд зөрүүд, сахилгагүй зан ааш гаргахад эцэг эхчүүд “хүчээр” асуудалд ханддаг. Сахилга баттай байна гэдэг нь хүүхдийг илүү хараат байдлаас бие даасан байдалд авчран, насанд хүрэхдээ үүрэг хариуцлагаа ухамсарласан бие хүн болоход нөлөөлдөг. Энэ нь хил хязгаар тавих тухай бөгөөд хил хязгаарыг тодорхойлох, тогтоох, тэдгээрийг мөрдүүлэх, батлах нь чухал. Үүний тулд эцэг эхчүүд дүрмийг зөрчихөөс өмнө хүүхдэд танилцуулах нь маш чухал. Тиймээс дүрмүүд нь товч тодорхой байх хэрэгтэй.



1. Урьдаас хил заагийг тодорхойл. - Хүүхдүүд эцэг эхийнхээ хайр халамж болон багшаас бүрэн хамааралтай байдаг. Тэдэнд мөн дүрэм журмыг танилцуулах хэрэгтэй байдаг. Зөрчигдөхөөс нь өмнө тэдгээр дүрмүүдийг юу гэдгийг хүүхдүүддээ хэлж ойлгуулах явдал чухал бөгөөд бага насны хүүхдүүдийн хувьд дүрэм нь товч бөгөөд тодорхой байх хэрэгтэй. Юуг хүсэн хүлээж байгаа, яагаад түүнийг хүсэн хүлээж байгаа, яагаад болохгүй гэдэг шалтгааныг хэлэх хэрэгтэй.

2. Зөрчигдсөн хил хязгаарыг тодорхойлж хэлж ойлгуулах явдал хамгаас чухал. Эцэг эхчүүд хүүхдийн хөгжлийн онцлогийн талаар мэдлэг, мэдээлэлтэй байхаас гадна мэдрэмжтэй хандах хэрэгтэй. Тухайлбал бага насны хүүхдүүдийн хувьд хөдөлгөөний ур чадвар хөгжиж буй үе

байдаг тул үйлдлүүд нь тогтвортой бус, үйлдлээ сайн хянах чадваргүй байдаг. Тиймээс, хүүхдийн тоглоомын хэсгээс үнэтэй шаазан ваар болон бусад эвдэрч болохуйц гоёл чимэглэлийн эд зүйлсийг хурааж гэнэтийн осол гарахаас урьдчилан сэргийлэх нь зүйтэй. Яагаад хил хязгаар зөрчигдсөн бэ? гэдэг шалтгааныг бид тодруулах хэрэгтэй. Энэ нь хүүхдийн гэнэн цайлган хариуцлагагүй байдал уу, эсвэл санаатайгаар эсэргүүцсэн үйлдэл үү? Бидний уур уцаар нь хүүхдийн эсэргүүцсэн үйлдлээс үүдэлтэй юу? Эсвэл бидний өөрсдийн сэтгэл санааны тогтворгүй байдал, нөхцөл байдал, бидэнд тулгарсан хүндрэл бэрхшээл юмуу? Эсвэл анхаарал болгоомжгүй байдлаас үүдэлтэй юу?

ХҮҮХЭДТЭЙГЭЭ УУРЛАЖ БУХИМДАЛГҮЙ ХАРИЛЦАХ НЬ.²

Уурлаж, хашхирах нь бидний бодож байгаатай адил үр нөлөөтэй биш. Энэ нь зүгээр л чанга дуу чимээнээс цаашгүй. Хувь хүнийг бүрдүүлэгч мөн чанарын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг бол сэтгэл санаа юм. Бидний сэтгэл санаа буюу сэтгэл хөдлөл хэт мэдрэг бөгөөд чанга дуу хоолойд сөргөөр хариу үйлдэл үзүүлээд зогсохгүй, ийм зуршилд өөрийн мэдэлгүй суралцдаг байна.

- ▲ Хүүхэдтэйгээ харилцахдаа “аянга цахилгаантай бороо” мэт бус харин зөв зохистой үг яриа, дуу хоолойны өнгө, биеийн хэлэмж ашиглах зайлшгүй шаардлагатай. Аянга цахилгаантай бороо юуг ч ургуулдаггүй, харин өсөлтийг зогсоож сүйтгэдэг гэсэн үг байдаг.
- ▲ Хүүхэдтэйгээ ярилцахад бидний дуу хоолойны өнгө ярианы агуулгатай тохирсон байх хэрэгтэй. Хэрвээ хүүхэд хайртай тоглоомоо алга

² Ли ви Мин, (2008). Эцэг эх байх нь галзуу хулганаар давхих мэт, УБ

болгоод гунигтай байгаагаа яривал нь хайхрамжгүй юмуу шүүмжлэлтэй хандахаас илүүтэй сэтгэлийг нь ойлгож, өрөвдөх хэрэгтэй.

- ▲ Ямар ч харилцаанд, бидний мэдрэхүүд хамгийн түрүүнд хүрдэг зүйл нь хэлэгдэж буй үг бус харин бидний дуу хоолойн чанга, сулын хэмжээ байдаг. Зарим хүн төрөлхийн чанга дуутай. Хүүхэдтэйгээ өдөр тутам харилцахдаа бидний гаргадаг ноцтой алдааны нэг бол дуу хоолойны хэмжээг анзаардаггүйд оршино.
- ▲ “Үгүй” гэж хэлэхээс өмнө бид эхлээд сайтар тунгаан бодох хэрэгтэй бөгөөд “Үгүй” гэдэг үгийг “Тийм” гэдэг үгтэй ямагт зохист тэнцвэртэйгээр хэлж байх хэрэгтэй.
- ▲ Ингэж хэлэхэд зөвхөн тэвчээр шаардагдаад зогсохгүй гаргасан шийдвэрийнхээ учир шалтгааныг цаг гарган тайлбарлахыг хэлнэ.



ХҮҮХЭДДЭЭ ХАЙРАА ХАРУУЛАХ АРГА ЗАМУУД. Өдөр бүр бид хүүхдэдээ хайраа илэрхийлж байх хэрэгтэй. Үүний тулд дараах алхмуудыг тогмол хийх нь хүүхдийнхээ хөгжилд оруулж буй асар том хувь нэмэр болно.

- ▲ Ямар нэг зүйлийг сайн хийх хичээл зүтгэл гаргасан үе бүрд нь магтан сайшаагаарай. Тухайлбал: Бусдад санаа тавих үед нь, сайн санаа өвөрлөх үед нь болон зөв сэдлээр хийсэн зүйл болгоных нь төлөө.
- ▲ Хүүхэд бүртэйгээ хувьчилсан цаг тогтмол гарга. Ингэснээр тэд таны хувьд чухал хүн гэдгээ мэдрэх болно.
- ▲ Үргэлж зааварлах юмуу тэдний өмнөөс шийдвэр гаргах бус харин тэднийг шийдвэр гаргахад нь туслах буюу удирдан чиглүүлээрэй.
- ▲ Хүүхдийн оролцож байгаа, өөрсдөд нь чухал арга хэмжээ болох спортын тэмцээн, концерт гэх мэт үйл ажиллагааг очиж үзэж, хүүхэдтэйгээ хамт байх.
- ▲ Харилцаагаа бэхжүүлэх боломжуудыг бий болго. Тухайлбал: Аялал зугаалга, тоглоом, ууланд гарах, салхинд гарах, хоол хийх, цэцгээ арчлах гэх мэт.
- ▲ Эцэг эхчүүдийн хүүхдэдээ өгч чадах хамгийн том бэлэг бол ханиа хайрлах, хайраа түүндээ харуулах явдал юм. Хожим үр хүүхэд чинь өөрийн гэсэн гэр бүлтэй болоход та ийнхүү үлгэр загвар болж чадна.



Гэр бүлийн хөгжлийн амьдралын үе шатуудын онцлог нь гэр бүлийг бүхэлд нь хамарч, гэр бүлд үүрэг хүлээлгэдэгт оршино. Гэр бүл өөрчлөгдөхийн тулд гэр бүлийн гишүүд ганц нэгээрээ биш бүгдээрээ өөрчлөгдөх шаардлагатай гэдгийг багш эцэг эхчүүдэд ойлгуулах хэрэгтэй. Учир нь гэр бүл гэдэг өөрөө эргэх холбоо учраас тахиа анхдагч

уу, өндөг анхдагч уу гэдгийн нэгэн адил энэ нь эхлэл болон төгсгөлгүй бөгөөд гэр бүл хэд хэдэн үе шатаар нэгэн зэрэг дамжиж байж болно. Гэр бүлийн бэрхшээлд ганцхан учир шалтгаан гэж байхгүй. Гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцаа холбоо, тэдний гадаад тогтолцоотой харилцах харилцаа холбоо нь гэр бүлийн системийн үйл ажиллагаа, төлөв байдалд нөлөөлнө.

.....

ХҮҮХДИЙГ ХАЙРЛАН ХАРИЛЦАХ. Эцэг эх ойр дотны хүмүүс хүүхэдтэй байнга харилцаж, тэднийг хайрлаж байх ёстой ба үүнийг хайрлуулах харилцах хэрэгцээ гэнэ.

- ▲ Намайг хүмүүс хайрлаж байна, би хүмүүст хэрэгтэй гэдгээ хүүхэл бүр багаасаа мэдэрч байх ёстой. Хүүхдэд ийм мэдрэмж хэрэгцээ төлөвшүүлэхэд эцэг эх, асран хамгаалагч, цэцэрлэгийн багш, туслах багш нарын үүрэг асар их юм.
- ▲ Хүүхдийг хайрлан харилцаж, мэдрэмжээ илэрхийлэхэд нь туслах
- ▲ Хүүхдийг магтан сайшааж, өөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэхэд туслах

Бага насны хүүхдүүдийг асран хамгаалж байгаа эцэг эхчүүд, асран хамгаалагч нарын харилцаа, хайр халамж түүний цаашдын бүх талын хөгжилд маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүүхдийн хайрын хэрэгцээ хомсдох, улмаар “хайрын өлсгөлөнд” нэрвэгдэх шалтгаанууд:

- ▲ Өнчрөх, төөрөх, эцэг эхдээ хаягдах
- ▲ Аав ээж нь хүүхдээ шоовдорлон, хүйтэн хөндий харилцах
- ▲ Хүүхэд өвчин эмгэгтэйн улмаас эцэг эхээсээ тусгаарлагдах
- ▲ Эцэг эх нь хэт завгүйн улмаас хүүхдийг зөнд нь орхих
- ▲ Хөндлөнгийн хүмүүс дээр удаан хугацаанд орхих

Хүүхдийг хайрлахдаа зөв хайрлах нь хамгийн чухал байдаг. Амьдрал ахуйн хэвшил, хоорондынхоо харилцаа зэрэг гэр орны хүрээнд болж буй бүхий л зүйлд ухаалаг хайраа шингээх нь эцэг эхчүүдийн ухааны ур чадвараас шалтгаална. Хүүхдийг зөв хайрлан харилцахад эцэг эх, өвөө эмээ нарын үүрэг нэн чухал юм. Бага насны хүүхдийг асран хамгаалж байгаа хүмүүсийн харилцаа, хайр халамж нь хүүхдийн цаашдын бүх талын хөгжилд маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Үүний тулд та:

- ▲ Хүүхдийг чин сэтгэлээсээ асран хайрла
 - ▲ Түүнийг өхөөрдөн энхрийл, элгэндээ нааж чанга тэвэр
 - ▲ Түүнтэй ярилц, өөрийнх нь хэлээр шулаганан ярилц
 - ▲ Өөртөө дасгаж, дотно дулаан харилцаагаа мэдрүүл
 - ▲ Хайр гэрэлтсэн харцаараа энхрийлж, хайрын уянгаараа бүүвэйлэн тайвшруул
 - ▲ Эцэг эхдээ итгэх хүүхдийн итгэл бол сарнай цэцгийн ялдамхан дэлбээн дээр дуссан хурын шүүдэр мэт нандин, ариухан зүйл юм.
-

ХҮҮХЭДДЭЭ МЭДРЭМЖЭЭ ТАНЬЖ, ИЛЭРХИЙЛЭХЭД НЬ ТУСЛАХ.

Хүүхэд бүр өөрийнхөөрөө аливаад ханддаг.

Энэ нь тэдний мэдрэмжтэй холбоотой ба мэдрэмж нь хүүхдийн хүмүүжлийн суурь юм. Та хүүхдээ ойлгож, түүнтэй ойр дотно харилцаатай байхын тулд хамгийн түрүүнд юу мэдэрч байгааг нь өөрт нь ойлгуулж, мэдрэмжээ илэрхийлэхэд нь тусалж, түүнийг нь хуваалцах хэрэгтэй. Мэдрэмж гэдэг нь хүн ямар нэгэн зүйлийг хүртэхүйн эрхтнүүдийн тусламжтайгаар хүлээн авч тусгахыг хэлдэг. Тэрээр энэхүү мэдрэмжийнхээ тусгалыг таниад, сэтгэл хөдлөлөөрөө хариу илэрхийлдэг. Уурлах, уйтгарлах, баярлах, гомдох, ичих, бахархах, хайрлах, эргэлзэх гээд бүгд л хүний мэдрэмжийн илэрхийлэл юм. Эцэг эх, хүүхдийн хооронд үүсдэг зарим нэг үл ойлголцлын шалтгаан нь эцэг эхчүүд хүүхдийнхээ мэдрэмжийг ойлгож хүлээн авдаггүйд оршино. Тулгараад байгаа бэрхшээл эсвэл баяр баяслаа бусадтай хуваалцсанаар хүүхдийн сэтгэл хөнгөрч, тухайн зүйлийнхээ учрыг олоод, даваг туулах чадвартай болдог. Харин мэдрэмжийг үгүйсгэх нь аливааг ухааран ойлгох боломжийг нь хааж, сэтгэл санаа, зан байдалд нь сөргөөр нөлөөлдөг.



ХҮҮХДИЙН ХҮМҮҮЖИЛД ЭЦЭГ, ЭХЧҮҮДИЙН ГАРГАДАГ НИЙТЛЭГ АЛДАА

Сэтэл зүйчид эцэг эхийн хүүхэдтэй ханддаг харилцааг судлаад алдааг юуны өмнө 2 зүйлээс үүсдэг гэж үзэж байна. Энэ нь :

1. Хүүхдийнхээ зан авир, төлөв байдлыг хянах
2. Хүүхэддээ сэтгэл хөдлөлөөр харьцах байдал энэ хоёрын аль нэгийг эсвэл хоёуланг зэрэг зөрчвөл хүүхдийнхээ хөгжил, төлөвшилд ноцтой гэм учруулна.

Гэр бүлийн сурган хүмүүжилд байнга тохиолдож байдаг нийтлэг алдааг гурван хэсэгт хувааж байна.

Нэг дэх алдаа: Хүүхэд эцэг эхийн сэтгэл \хайр\ илрэн гарах онцлогийн талаар эцэг эхийн өөрсдийнх нь дутмаг хийгээд буруу ойлгодог.

Хоёр дахь алдаа: Хүүхдийнхээ нас, биеийн онцлогийн тухай эцэг эхчүүдийн сэтгэл зүйн дутмаг мэдлэг, сурган хүмүүжлийн үр нөлөөтэй арга барилын дутагдал, мухардал.

Гурав дахь алдаа: Эцэг эхийн хувийн үлгэр жишээ, хүүхдийн өмнө гүйцэтгэвэл зохих өөрсдийн үүрэг, тавьж буй шаардлагын нэгдлийг дутуу үнэлэх явдал юм.

ХҮҮХЭДТЭЙГЭЭ ХЭР ЯРИЛЦДАГ ВЭ? Та хүүхэдтэйгээ хэдий чинээ ярилцана, тэдэнд төдий чинээ оюун ухаанаа хөгжүүлэх боломж олгож байдаг. Тухайлбал

- ▲ Тодорхой хугацаанд хүүхэдтэйгээ тоглож бай. Ингэснээр хүүхдэд шинийг мэдүүлж, оюун ухааныг нь хөгжүүлэхийн зэрэгцээ түүний байр байдлыг мэдэх боломжтой.
- ▲ Хүүхэдтэйгээ байнга аль болох их ярилцахыг хичээ.
- ▲ Хүүхдээ ганцааранг нь чимээгүй өрөөнд удаан бүү байлга
- ▲ Хүүхэд \ач жич\ тэйгээ том хүнтэй ярилцаж байгаа юм шиг ярилцахыг хичээ. Тэд таны яриаг сайн ойлгоно. Та ажигладаг биздээ. Хүүхдүүд гарч буй кино, ярьж буй зүйлийг ойлгодог. Тэр ч байтугай бүжгийн хөдөлгөөн хийх, гүйцэд тогтоогоогүй дуугаа аялах, шүлэг уншихыг оролдож, киноны үйл явдлаас ярих гэдэг шүү дээ.

СУРГААЛТ ҮГ. Сургаалт үгс нь гүн гүнзгий, өргөн дэлгэр агуулгатай, хүүхдийг аргадахаас эхлээд анхааруулах, айлгах утга санааг багтаадаг. Хүүхдийн мэдээ орохыг дагалдан сургах үг, өгүүлбэр нь агуулгын хувьд аяндаа гүнзгийрдэг. Монголчуудын гэрийн сургаал үгс нь бага насны хүүхдэд сургаал болж, сургуульд суусны хойно тэр, ажил амьдралын замд орсны дараа ч тэр, “Зуу хүрэвч журам ёсыг дагана” гэдэгчлэн хүн болж төрөөд өтөлтөл нь ухаарал болсоор байдаг билээ. Монголчууд ардын билэг зүйтэй танилцахыг их ач холбогдолтой гэж үздэг. Энэ талаарх анхны сургалт юунаас эхэлдэг байв? Анхны сургалт хүүхдийн тоолол, оньсого, зүйр цэцэн үгнээс эхэлж, дараа нь үлгэрт шилжиж, цаашлаад овог, аймаг, улсын түүх, гарал үүсэлтэй холбоо бүхий хууч яриа, домог, туульсын амтанд ордог уламжлалтай.

ҮГ-ЗҮЙР ЦЭЦЭН ҮГ. Монголчуудын бага насны хүүхдээ сурган хүмүүжүүлэх аргын нэг нь аливааг тайлбарлан таниулах явдал юм. Хүүхэд бага насандаа саваагүйтэж алдаа гаргаж байдаг. Энэ нь тэдний гэм биш зан. Харин дээрх үйлдэл болгонд уурлан ундууцах, зандарч аашлах нь оновчтой биш. Алдаа дутагдлыг нь ойлгуулж, энэ чинь буруу юм гэдгийг тайлбарлан ойлгуулах нь илүү ач холбогдолтой. “Хүн хэлээрээ мал хөлөөрөө” гэдэг дээ. Харин ингэж ойлгуулахад үг онцгой үүрэгтэй. -Энэ чинь ингэдэг юм, -тэгдэг юм гэж зүгээр тайлбарласнаас түүнтэй нь холбоотой зүйр цэцэн үгийг ашиглах нь үр дүнгээр илүү. Зүйр цэцэн үгнүүд нь утга санаа баялаг төдийгүй хүүхдийн хүмүүжил хийгээд хэл ярианы соёлд чухал үүрэгтэй. Жишээлбэл:

Хүндлэх ёсны талаар

НАС	ЗҮЙР ЦЭЦЭН ҮГ	ХЭРХЭН ТАЙЛБАРЛАН ТАНИУЛАХ ВЭ?
4-6	Хүн ахтай дээл захтай Хүний бага нь хөдөлж Шувууны бага нь жиргэдэг	▲ Дээл болгон захтай байдгийн адил хүн бүрт ах гэж бий. Монголчууд эртнээс нааш дээлийнхээ захыг хүндэтгэж, үүд рүү харуулахгүй, хөл дор хаялгүй хүндэлдэг. Түүний нэгэн адил хүн өөрөөсөө насаар ах хүний үгийг нь сонсож хүндэлж байдаг заншилтай. ▲ Бага хүүхэд гэдэг аливаад дуулгавартай байж гэр зуурын ажилд том хүнээс урьтан хөдөлж байдаг учиртай.

Эрдэм мэдлэгийн үр шимийг ойлгуулахад

НАС	ЗҮЙР ЦЭЦЭН ҮГ	ХЭРХЭН ТАЙЛБАРЛАН ТАНИУЛАХ ВЭ?
4-6	Эрдэмгүй хүн сохортой адил Эрдэмгүй бол ажилгүй Ажилгүй бол хоолгүй	▲ Сохор (хараагүй) хүн хорвоог харж чадахгүйтэй адил эрдэмгүй хүн оюуны далайд сохор мэт байх болно. ▲ Хоолоо олохын тулд хүн ажиллах хэрэгтэй. Харин ажлыг эрдэмгүйгээр хийж гүйцэтгэж чадахгүй

Та хүүхэддээ үлгэр ярихдаа юуг анхаарвал зохих вэ? Хүүхэд үг хэлж чадах болсон үеэсээ үлгэр сонсохыг шаарддаг. **Үлгэр ярихдаа:**

“Үлгэр дагавал цэцэн болно” Үлгэрийн эхлэл нь хүүхдийн

дур сонирхлыг ихээхэн татаж байдгийг санаарай. Хүүхэд үлгэр хэрхэн эхлэхийг чих тавин, амьсгаагаа даран хөдөлгөөнгүй суун хүлээдэг. Тэгэхээр үлгэр ярих эхлэл янз бүр байх шаардлагатай болно. Жишээ нь: Асуух хэлбэртэй эхэлбэл: “Чи мэдэх үү ? Унаганы эх нь хэн бэ?”, “Унаганы эх нь түүнд эрдэм чадлыг хэрхэн зааж өгсөн бэ?”, “Би чамд нэг (унага гол гаталсан) үлгэр ярьж өгье болох уу?” гэх зэрэг. Үлгэрийг сонирхолтой хэлбэрээр эхэлбэл хүүхэд дуртай сонсдог. Дуртай шимтэн сонсвол анхаарал нь төвлөрч байгаа төдийгүй үлгэр тогтоох нь сайн болно. Юм бүхний учрыг хүүхэд байнга асууж шалгаах учир уурлаж уцаарлалгүйгээр үгийг нь тэвчээртэй сонсч, уйгагүй тайлбарлаж өгөх, Сайн муу, сайхан муухай үйл явдал, үзэгдлийг үлгэрийн баатруудаар илэрхийлэн ойлгуулаарай.



ТОГЛООМ-ХҮҮХДИЙГ АЖИЛСАГ БОЛГОХ ЭХЛЭЛ. Тухайлбал:

хүүхдийн бүтээлч сэтгэлгээ, эрэгцүүлэн бодох чадвар, авхаалж самбааг нэмэгдүүлнэ. Хамтран тоглох явцад өөр хоорондоо ярилцаж улмаар бие биедээ тусалж, дэмжиж сурна. Зөв зохион байгуулсан тоглоом наадам хүүхдэд үерхэл, нөхөрлөлийн гайхамшигт сайхан чанарыг бататгаж сэтгэлийн нь хөгжүүлнэ. Хүүхдийн анхаарлыг нь хөгжүүлэх гол хэрэгсэл бол тоглоом. Хүүхэд тоглох явцдаа анхаарлаа сайжруулна. Өвөг дээдэс маань: “Хүүхдийг сайн танья гэвэл хэрхэн тоглож байгааг нь хар” гэдэг дээ. Эндээс Та хүүхдийн (ач, зээгийн)- хээ ямаршуу зан араншинтай бойжиж, тэдний танин мэдэхүйн төвшин хэр зэрэг байгаа, түүнчлэн уйгагүй чанар, тэвчээр гээд олон зүйлийг ажиглаж мэдэж авна. Тоглоом нь хүүхдийг сургаж, хүмүүжүүлэхийн нэг чухал арга, хэрэгсэл болдог. Монгол ардын тоглоом нь хүүхдийг зугаацуулахын зэрэгцээ нэг их хүч хөдөлмөр шаардахгүйгээр сонирхон тоглох явдал нь хүн ардынхаа ахуй амьдрал, зан заншил, ёс суртахууны тухай ойлголттой болж, хэл яриа, оюун сэтгэлгээ хөгжүүлдэг. Хүүхэд тоглож байх үедээ байгаль, нийгэмтэй харьцах арга, дадал чадварыг олж эхэлдэг. Хүүхдийн нас, бие, сэтгэцийн онцлогийг харгалзан хүмүүжлийн арга, хэлбэрт ялгавартай хандах нь хүний төгс чанар бүрэлдэх явцыг зорилготой, тодорхой болгодог байна.

ҮЛГЭР ДУУРИАЛАЛ – ХҮМҮҮЖИЛ. Хүүхдэд юмыг ингэдэг юм гэж зааж сургахаас илүү дуурайлгах замаар зөв хэвшил дадал бий болгох. Яагаад гэвэл хүүхэд юмыг тусгах тал илүү байдагтай холбоотой. Тэгэхлээр эх эцэг улмаар эмээ өвөө таны зөв дуурайл чухал, хүүхдийн нүдэнд зөв харагдаж, чихийг нь халууцуулахгүй байх ёстой болж байгаа биз.

Монголчууд хүүхэд багачуудад юмыг хийсвэрээр заан сургахыг эрхэмлэдэггүй, үзэгдэж баригдам бодитой зүйлсээр дамжуулан таниулж мэдүүлдэг. Бодит амьдралаар хүмүүжүүлэх гэдэг нь хүүхэд болон насанд хүрэгсэд нэг дор хамт аж төрөн сууж, дор дороо өөр өөрийн үүргийг биелүүлж, бие биесээ хүндэтгэж ойшоож ханддаг байхын нэр юм. Энэхүү хамтын үйл ажиллагааны дүнд хөдөлмөрлөхийн сацуу суралцаж, суралцахын сацуу хөдөлмөрлөдөг. Үзүүлж харуулах, ярихын сацуу ажил хөдөлмөр, хамтын үйл ажиллагааг ямагт дагалдуулдаг. “Үүнийг ингэж хэлдэг юм”, “Алив миний хүү нэг оролдоодох, болох нь уу”



гэх зэргээр эцэг, эх нь хүүхдээ өөртөө туслуулах маягаар сургана. Ер нь хүүхэдтэйгээ хамт “бүтээх” зарчмаар ажилладаг. Хүүхдийг хүмүүжүүлэхэд хамгийн гол нь аливаа зүйлийг өөрөөр нь ухааруулах, биеийг нь даалгаж алив зүйлийг шийдүүлж, хийлгэж сургах явдал юм. Энэ нь жижиг зүйлээс эхэлнэ. 3-6 насны хүүхдүүд сайн, муу, сайхан, муухайг ухварлан үл ойлгох учраас тэдэнд үлгэр дуурайл үзүүлэх, дэргэд нь хэрэлдэх, хүүхдийн “чих халууцах” томчуудын хов жив, элдэв явдлыг цээрлэдэг уламжлалтай. “Аав надад алим авч өгч билээ...” Энэ юу гэсэн үг вэ? Энэ явдал хүүхдийн 4 настай байхад болжээ. Энэ үгийг 20 жилийн дараа хүүхэд нь аавдаа хэлжээ. Мэдээж, аав нь үүнийг мартчихжээ. Аав нь “Өө тэгсэн бил үү?” гэж хариулсан байна. Хүүхдийн энэ үг юуг илтгэж байна вэ? Аав нь хүүхдүүдтэйгээ цугтаа байх нь хүүхдийн хувьд үл мөр үлдээдэг, мартагдашгүй байдгийг харуулж байгаа биз. Тэгэхлээр хүүхдийн хүмүүжилд аавын гүйцэтгэх үүргийн асуудал гэрч ирнэ. Энэ нь юу вэ? гэвэл:

- ▲ Өрх гэрийн амьдралыг зохион байгуулах, удирдахад голлох, хүүхдээ хүмүүжүүлэхэд чиглүүлэх үүргийг гүйцэтгэдэг.
- ▲ Бидний уламжлалын дагуу аав нь хүүхдийнхээ хүмүүжлийг ээжид нь бүрэн даатгадаггүй. Гэхдээ хүүхдийг хүмүүжүүлэх арга барилыг ээж нар илүү эзэмшсэн байдаг онцлогтой. Тийм ч байх ёстой биз ээ.

Аав нь охинтойгоо, хүүтэйгээ ярилцана. Охин, хүү нар их баяр хөөр. Харин аав болон том хүний хувьд мэдээжийн ч юм уу гэмээр санагдах зүйлсийг хүүхэд ярьдаг, ярилцдаг. Аав таны зан араншин, харилцах байдал хүүхдийн чинь зан төлөвшилд багагүй нөлөөлдөг. Жишээлбэл, Өмөөрдөг аав: гэхэд л эцгийн зүгээс хүүхдээ байнга “бөцийлдөг”, ер нь “хүүхдийнхээ төлөө явна”. Энэ нь эцэстээ ямар үр дүнд хүрэх бол. Өв тэгш аав, хөндий аав, танхай аав, наалинхай аав, номхон дорой аав, халамжтай аав гээд л хүүхэддээ хандах хандлага нь ялгаатай.

Тэгэхлээр аавд хариуцлага ноогдож байгаа биз. Дуугарах үг яриа утга учиртай байх шаардлагатай. “Аавын сургаал алт” гэдэг.

Аав хүүхдээ байнга анхаарч, сурган хүмүүжлийн ажилд (үе үе биш) оролцож байх. “Ажилд яваад ядарлаа. Саяхан ирлээ. Ингээд явна” гэх явдлыг хүүхдийнхээ тухайд хэрхэвч гаргаж болохгүй. Цаг боломжийг хүүхдэд зориулж байхыг хичээ. Ингээгүйгээс аав та хүүхдийнхээ өмнө алдаа гаргахад хүрнэ. Тухайлбал: аав танаас хүүхдэд чинь хүрч байх хайр халамж алдагдана. Хүүхдээ “чөлөөтэй” хүмүүжлийн орчинд оруулна. Хүү (охин) чинь ганцаардаж ч болно. Эдгээрээс ямар үр дагавар үүсч хөгжих вэ? гэдгийг аав та бод доо. Ер нь хүүхдэд хааяа зэм хүртээчихээд явдаг аав байж таарахгүй.




Зааж сургасан утгатай үгс	1	Миний охин анхааралтай байгаарай
	2	Битгий тэгж бай
	3	Миний охин алдаагаа засаарай
	4	Миний хүү сайн чадна
	5	Хайртай шүү миний хүү
	6	Дахиж тэгш болохгүй шүү
	7	Дахиж буруу юм битгий хийгээрэй
	8	Алдаагаа засаж сур

Хүүхдүүддээ хэлсэн сөрөг үгс хүүхдүүдэд яг адилхан утгаар хүрч, харин эерэг үгс нь тэдэнд дотно сэтгэгдлийг төрүүлдэг бололтой. Хүүхдүүдийн хамгийн ихээр эмзэглэдэг үгс:

- ▲ Заваан, арчаагүй
- ▲ Тэнэг, мангар
- ▲ Өөрчлөгдөхгүй гэх
- ▲ Боль, чи чадахгүй

Ядарч туйлдсан, ууртай байх үедээ хүүхдэдээ ямар нэгэн хатуу, ёжтой үг хэрэглэхгүй байхыг хичээгээрэй. Ээж аав та нар бяцхан хүүхдүүддээ голдуу ямар ямар үгийг бодлогогүйгээр хэлж байгаа вэ? Эргэн бодоорой!!! Сөрөг утга бүхий үг, үг хэллэг хүүхдэд нөлөөлөхдөө сэтгэлзүйн хувьд тогтворгүй байдлыг бий болгож, дарамтанд оруулдаг. Бие биенээ үгээр хүчирхийлдэг хүмүүсийн хүүхдүүд гол төлөв сэтгэлээр унасан зовнилтой байдаг бөгөөд амьдралдаа бусадтай харилцах харилцаандаа асуудалтай байдаг. Эцэг эхийн хоорондох үгийн хүчирхийлэл нь тэдний хоорондох бие махбодын хүчирхийллээс илүү хүүхдийг цочиролд оруулдаг. Сэтгэл хангалуун баяр хөөртэй, ерөөлтэй, сэтгэлд тавтай зэрэг утгыг бүгдийг нь багтаасан хамгийн тохиромжтой үг бол “аз жаргал” гэдэг үг юм.



ҮГ ГЭДЭГ ИХ ХҮЧТЭЙ. Үүний учир юунд байна вэ? Хүүхдийг өөрийгөө дайчилдаг болгодог. Өвөг дээдэс маань үгийн сурган хүмүүжүүлэх үнэ цэнийг өндөрт тавьж иржээ. Сайхан үг хүнийг ажил амьдралын замаа зөв сонгож, өсөн дэвжихэд тус дэм болдог бол бодлогогүйгээр хэлсэн болчимгүй үг нөхрийн санаа сэтгэлд хар толбо үлдээж болохыг харгалзан монголчууд сайн үгийг эмтэй, муу үгийг сумтай зүйрлэдэг. Тухайлбал: “Үг хатуу боловч амьдралд тустай”, “Амаар алж үгээр үхүүлдэг” гэдэг. Үг ухааран ойлгож чадах хүнд тодорхой эзэнтэй, улиглахгүй зөв хэлж сургахыг аргачлан заадаг байна.

Эцэг эхчүүд танин мэдэхүйн хөгжилтийг хэрхэн дэмжих вэ?

- ▲ Юмыг цаашид улам лавшруулан сонирхож судлах боломжоор хангах. Хүү (охин), ач, зээ нар чинь удахгүй сургуульд орно шүү дээ. Хүүхдүүд бол ямагт идэвхтэй суралцагчид, өөрсдийнхөө мэдэрсэн болгоныг нь анхааран үзэж, урамшуулж байхыг шаарддаг.
- ▲ Хүүхэдтэй ярьж хөөрч, яриаг нь хөгжүүлэх. Энэ нь хүүхдийн хэл ярианд их ач холбогдолтой. Тэдний үгсийн санг нэмэгдүүлэх талаар аль болох хичээх.
- ▲ Хүүхдэд уншиж өгөх. Үүнийг нэлээн эрт эхлэх хэрэгтэй. Тэгэхдээ хүүхдийн нас байдалд нь тохируулна. Жишээ нь: Хүүхэд зурагтай номын (бөмбөг, тоглоом зэрэг) олон зүйлийг зааж гардаг. Үүнийг нь хайхрахгүй байж болохгүй. Та зааж байгаа зүйлийнхээ өнгө, хэлбэр зэргийг хэлж тайлбарлан цаашид өргөжүүлэх.
- ▲ Эцэг, эх хүүхдийн хоорондох “товч харилцааг” бататгах. Харилцаанд хугацаа багадахгүй. 20,30 секундын харилцаа ч үр дүнтэй байж болно та нар хичнээн завгүй байсан ч маш бага хугацааг ч гэсэн хүүхдэдээ зориулж, тэдэнд анхаарлаа хандуулбал үр дүнтэй.



ХҮҮХЭДТЭЙГЭЭ ХАРЬЦАХДАА ЯМАГТ ТЭДНИЙ БАЙР СУУРИНААС ХАНДАЖ БАЙ ГЭДЭГ. ЯАГААД ТЭР ВЭ?

Аливаа юмыг харах, сонсох, ойлгох, дүгнэхдээ бид хүүхдээсээ огт өөрөөр ханддаг. Энэ нь нэг талаар зөв. Бид чинь нас бие гүйцсэн улс. Гэтэл хүүхэд маань үгүй шүү дээ. Тэгэхээр тэднийг аль болох ойлгож, хүүхэдтэйгээ хамт юм үзэх, ярилцах, тоглох явцдаа өөрсдийгөө тэдний байр суурин дээр аваачих нь хүүхдээ улам сайн ойлгоход тусална. Хүүхэд маань бидний ойлгоогүй, төдийлөн ажиглаагүй, санаагүй зүйлийг олоод ажиглачихсан байдаг. Тэдэнд биднээс илүү сэтгэх явдал гардаг гэдгийг мартаж болохгүй. Ийм тохиолдолд бид “Өө, тийм байж шүү дээ. Миний хүү нэг юм хэлээд байсан юм. Тийм юм байсныг нь харсангүй ээ” гэж ярьж байх жишээ олон бий.

Ялангуяа ээж нар харцаараа юмыг ойлгуулж, хүмүүжүүлэг байх нь чухал. Магтаал зэмлэлийн аль алиныг нь зөвөөр хэрэглэвэл хүүхдийн чадварыг хөгжүүлэхэд үр дүнтэйгээр нөлөөлдөг. Хүүхэд 6 нас хүрсний дараа түүнд олон зүйл өөрчлөгдөнө. Хүүхэд эцэг, эхээс хараат бус байдалд шилжинэ. Хүүхдээс ажилд хандах хандлага, хүлээх хариуцлага нэмэгддэг. Хүүхэд өөрийн хувийн зан чанар, мэдрэхүйг бий болгож, хүндлээсэй гэж хүснэ. Эдгээр өөрчлөлтийг та бүгд хүүхдээ хүмүүжүүлэх үйл ажиллагаандаа тун сайн анхаарч байгаарай.

Үр хүүхдийнхээ ачлал хайрыг хүсвэл өсөх насанд нь ажил, эрдэм сургаж, зөв хүмүүжүүлвэл өтөл насанд чинь шүтэн бишрэгдэж, сэтгэл амгалан байна шүү дээ.

Сургаал үг

НОМЗҮЙ

- МГБССН-ийн www.mfwa.mn веб сайт
- “Хүүхдийн хүмүүжлийн гарын авлага” МУБИС
- Бэлгийн амьдралын талаар... гарын авлага ЭМХҮТ, GTZ
- www.Emch.mn
- www.network.mn